

ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024.11.15

Улаанбаатар хот

Үндэслэл, шаардлага:

Хууль эрх, зүйн үндэслэл: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлолт хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална”, 11 дүгээр зүйлийн 11.2-т “Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг санхүү, төсвийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно”, 14 дүгээр зүйлийн 14.8.6-д “Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах” гэж тус тус заасан.

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах нь эрүүл мэнд, өвчин эмгэгийн эрсдэлтэй хүнийг эрт илрүүлэн, цаашид даамжруулахгүй эмчилж, сэргийлснээр эрүүл мэндийн зардлыг бууруулах болон иргэдийн чанартай амьдрах жилийг уртасгах ач холбогдолтой. Гэхдээ нийт хүн амыг хамруулсан компани тус болгон зохион байгуулж буйг өөрчилж, анхан шатны тусламж, үйлчилгээг бэхжүүлэх бодлоготой уялдуулан тодорхой эрсдэл бүхий зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлага тулгарч байна. Олон улсын туршлагаас харахад эрт илрүүлгийг нийт хүн амд бус зорилтот бүлгийн хүн амд чиглүүлэх, нийтийг хамарсан нэмэлт арга хэмжээ гэхээс илүү одоогийн анхан шатны тусламж, үйлчилгээний хэсэг болгон хэрэгжүүлэх, эрт илрүүлгийн шинжилгээ, насны бүлэг зэргийг сонгохдоо зардал-үр ашигийн шинжилгээ хийх, эрт илрүүлэгт хиймэл оюун ухаан ашиглах зэрэг гол зөвлөмж, чиг хандлагыг онцолсон байна.

Энэхүү тогтоолд сургуульд суурилсан эрт илрүүлэг ба хавдрын эрт илрүүлгийн багц, эрсдэлт бүлгийн хүн ам, шинжилгээний төрөл, анхан ба лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын үүрэг, уялдаа холбоо, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээний төлбөрийг санхүүжүүлэх журмыг тусгасан.

Сургуульд суурилсан эрт илрүүлгийн хувьд хүүхдийн насны онцлогт буюу 6, 12,15 настанд тохирсон эрүүл мэндийн үзлэг ба оношилгоо хийж, эрсдэлт хүчин

зүйлийг үнэлэн нэгдсэн мэдээллийн сан үүсгэхэд чиглэсэн. Хавдрын эрт илрүүлгийг эрсдэлт бүлгийн хүн амд зонхилон тохиолдох хавдрыг илрүүлэх өвөрмөц оношилгоо, шинжилгээг өвчин бүрийн эмнэлзүйн алгоритмийн дагуу илрүүлэхэд чиглэж байгаагаараа онцлог юм.

Өнөөгийн нөхцөл байдал:

Эрүүл эндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” 10 дугаар тогтоолын хүрээнд 2024 оны 10 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 1 544 968 хүн буюу нийт хүн амын 45,7 хувь нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 онд 17.4 тэрбум, 2023 онд 42.5 тэрбум, 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 25.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Нийт үзлэг оношилгоонд хамрагдсан даатгуулагчдыг насны багцаар авч үзвэл 0-5 насны 207 808 /47,3%/ 6-17 насны 527 545 /65.0 %/, 18-30 нас 155 553 /27,1%/, 31-45 насны 286 363 %/, 46-60 насны 243 993 /47.0 %/, 61-ээс дээш насны 123 706 /47.3%/ тус тус хамрагдсан байна.

Улсын хэмжээнд 1 261 885 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өвчлөлийн тэргүүлэх 3 шалтгаан болох хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин 694 558 тохиолдол буюу 55.0 хувь, дотоод шүүрэл ба бодисын солилцооны өвчин 187 253 буюу 14.8 хувь, шээс, бэлгийн тогтолцооны эмгэг 120 249 буюу 9.5 хувийг тус тус эзэлж байна.

Эрт илрүүлэгт хамрагдсан 731 312 насанд хүрсэн иргэдийн 59614 хүн буюу 8% нь С вирустэй, харин 20360 хүн буюу 3% хувьд нь элэгийн В вирустэй байна. Элэгний хавдрын урьдал өвчин болох элэгний В,С вирус болон циррозтой иргэдийг тогтмол үзлэг, оношилгоонд хамруулж, холбогдох эмчилгээ, хяналтыг хийснээр элэгний хорт хавдрыг эрт илрүүлж, эмчлэх боломж бүрдэнэ.

Уушигны хавдрын эрсдэлт хүчин зүйл болох тамхи татдаг иргэдийг өмнөх эрт илрүүлгээр тодруулсан бөгөөд 50 дээш настай тамхи татдаг иргэн 41 947 байна. Энэ бүлгийн хүмүүст эрт илрүүлгийг тамхинаас гаргах хөтөлбөртэй хослуулан хэрэгжүүлснээр уушигны хорт хавдраас сэргийлэх боломжтойг тодорхойлсон эмнэлзүйн нотолгоо байгаа ч зардлын үр дүнг тооцож, зорилтот бүлгийг илүү тодорхой болгох шаардлага тулгарч байна.

Эрт илрүүлгийн багц нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.1.3 дахь хэсэгт заасан “Эрүүл шүд”, “Хорт хавдраас сэргийлэх, хянах”, зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх “Эрүүл Монгол”

хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.” гэсэн заалттай уялдсан бөгөөд дараах чиглэлийг тусгасан. Үүнд:

- Эрт илрүүлгийн үзлэгийн багцад хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх багажийн болон лабораторийн шинжилгээ, бодит үзлэгүүд үр дүнтэй байсан тул 6 төрлийн хорт хавдрын илрүүлгийг цаашид үргэлжлүүлэх
- Эрт илрүүлгийн насны товлалыг судалгааны үр дүнг үндэслэн өөрчлөх, хүүхэд насанд нүд, шүд, зүрхний эрт илрүүлгийн ажлыг зохион байгуулах.
- Ажил олгогчийн хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хэрэгжүүлдэг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэгийг эрт илрүүлэгтэй уялдуулж, мэдээллийн нэгдсэн санд холбож, эргэн мэдээлэх тогтолцоог бий болгох.
- Халдварт өвчний илрүүлгийг илүүтэй зорилтот бүлэг рүү чиглүүлж, идэвхтэй илрүүлгийн тусдаа хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.
- Эрт илрүүлгийн орчин үеийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх (тухайлбал, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт ХПВ-ын өндөр эрсдэлт хэв шинжийг илрүүлэх шинжилгээг хослуулан хэрэглэх).

Тогтоолын ерөнхий бүтэц:

1. “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам”
2. “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ”

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт дараах багцыг тодорхойлсон. Үүнд:

“Сургуульд суурилсан” эрт илрүүлэг

“6 настаны”-ы эрт илрүүлэг

“12 настан”-ы эрт илрүүлэг

“15 настан”-ы эрт илрүүлэг

. Хавдрын эрт илрүүлэг

2.1. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг

Улаан хоолой, ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг

Бүдүүн гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг

Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг

Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг

Уушигны хорт хавдрын эрт илрүүлэг зэрэг болно.

Ургийн болон нярайн эрт илрүүлэгийн хүрээнд хийгдэх оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлэх боломжтой, мөн ажлын байран дах эрт илрүүлэг нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцахаар заасан байх тул Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрт илрүүлгийн багцад оруулаагүй болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР